



Г “АЛТАН ДАВАЛГАА” ХЗХ-НД 7

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.04.05 № ЦМ-8/11

танай 2023.03.14 -ны № 23/131 -т

Г Сонгуульт гишүүдийн өөрчлөлт 7
бүртгэсэн тухай

Танай хоршооноос 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн сонгуульт гишүүдийн өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 8.2-т заасны дагуу хянаж үзээд холбогдох бүртгэлд дараах өөрчлөлтийг бүртгэсэн болно. Үүнд:

№	Хамаарал	Овог, нэр	Тайлбар	
1	Тэргүүлэгчдийн зөвлөл	Дарга	Б.Цэрэнлхам	улируулан
2		Гишүүн	Н.Энхтуяа	улируулан
3		Гишүүн	Б.Баярсайхан	улируулан
4		Гишүүн	Г.Содонцэцэг	шинээр
5		Гишүүн	Л.Чинзориг	шинээр
6	Хяналтын зөвлөл	Дарга	Ч.Жадамба	бүртгэлтэй
7		Гишүүн	Г.Сундуй	бүртгэлтэй
8		Гишүүн	Ш.Дэмчиггарав	бүртгэлтэй
9	Зээлийн хороо	Дарга	З.Батцэцэг	бүртгэлтэй
10		Гишүүн	Г.Отгонпүрэв	бүртгэлтэй
11		Гишүүн	Б.Баасанцэрэн	бүртгэлтэй
12	Гүйцэтгэх захирал	З.Батцэцэг	бүртгэлтэй	
13	Нягтлан бодогч	Э.Нямдэлгэр	бүртгэлтэй	

Ирүүлсэн баримт бичигтэй танилцахад бүх гишүүдийн хурлын үеэр тухайн хурлыг удирдах тэргүүлэгч гишүүдийг томилж, хурлын тэргүүлэгчээр бүх гишүүдийн хурлын шийдвэрт гарын үсэг зуруулж байгаа нь дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Бүх гишүүдийн хурлыг тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, түүний эзгүйд тэргүүлэгчдийн зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч удирдана.”, 33.2-т “Бүх гишүүдийн хурлаас хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг сонгоно.” гэж тус тус заасантай нийцэхгүй байгаа тул бүх гишүүдийн хурлыг зохион байгуулахдаа хуульд заасан дэгийг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

